



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/181

Шивээговь сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Иргэн Ташигад овогт Сандагийн Оюунсайхан /УД70010415/ нь Шивээговь сумын 2 дугаар баг, Алсын худгаас урагш байрлах өвөлжөө, хаваржааны зориулалттай 700м2 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тул 15 жилийн хугацаатайгаар сунган эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй иргэн (С.Оюунсайхан)-д газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг хуулийн дагуу сунгаж буй иргэн С.Оюунсайхантай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг сумын Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 56 дугаар захирамжийн 1 дэх бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА